

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянцагаан сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БНА-2026/020/НА- СТА-ОНТС

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор хот

2026

2026 оны 02 дугаар сарын 11-ний
өдөр

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын

Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат

Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Ахлах аудитор М.Алтантуяа

Утас: 70442424 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Должмаа

Утас: 88110538 Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

1.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>175,681,827.50</u>	<u>251,656,914.50</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	58,611,409.50	177,696,914.50
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	58,611,409.50	177,696,914.50
3121	Төгрөг	58,611,409.50	177,696,914.50
31211	Төрийн сангийн харилцах	58,611,409.50	177,696,914.50
33	АВЛАГА	16,500,000.00	27,960,000.00
335	Бусад авлага	16,500,000.00	27,960,000.00
3351	Байгууллагаас авах авлага	16,500,000.00	27,960,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	100,570,418.00	45,000,000.00
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	100,570,418.00	45,000,000.00
36	НӨӨЦИЙН БАРАА	00.00	1,000,000.00
36100	Барааны нөөц	00.00	1,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>175,681,827.50</u>	<u>251,656,914.50</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>175,681,827.50</u>	<u>251,656,914.50</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	175,681,827.50	251,656,914.50
512	Хуримтлагдсан үр дүн	175,681,827.50	251,656,914.50
51210	Өмнөх үеийн үр дүн	175,681,827.50	175,681,827.50
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	75,975,087.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>175,681,827.50</u>	<u>251,656,914.50</u>

1.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	702,815,703.00	732,085,486.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	41,820,033.00	11,211,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	41,820,033.00	11,211,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	41,820,033.00	11,211,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	41,820,033.00	11,211,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	660,995,670.00	720,873,986.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	54,481,170.00	83,120,086.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	54,481,170.00	83,120,086.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	606,514,500.00	637,753,900.00
1330	Төсвийн захирагчдаас	606,514,500.00	637,753,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	832,978,778.50	664,270,399.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	00.00	8,160,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	00.00	8,160,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	8,160,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	8,160,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	832,978,778.50	656,110,399.00
2200	Дотоод эх үүсвэрээр	832,978,778.50	656,110,399.00
220001	Барилга байгууламж	832,978,778.50	00.00

223001	Бусад хөрөнгө	00.00	656,110,399.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	130,163,075.50	67,815,087.00
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	00.00	8,160,000.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	00.00	8,160,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	8,160,000.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	130,163,075.50	75,975,087.00

1.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	724,170,670.00	773,190,904.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	63,175,000.00	52,316,918.00
120	Нийтлэг татварын бус орлого	63,175,000.00	52,316,918.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	63,175,000.00	52,316,918.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	63,175,000.00	52,316,918.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	660,995,670.00	720,873,986.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	660,995,670.00	720,873,986.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	54,481,170.00	83,120,086.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	606,514,500.00	637,753,900.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	724,170,670.00	773,190,904.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	780,478,778.50	654,105,399.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	780,478,778.50	654,105,399.00
2200	Дотоод эх үүсвэрээр	780,478,778.50	654,105,399.00
220001	Барилга байгууламж	780,478,778.50	00.00
223001	Бусад хөрөнгө	00.00	654,105,399.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	780,478,778.50	-654,105,399.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-56,308,108.50	119,085,505.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	114,919,518.00	58,611,409.50
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	58,611,409.50	177,696,914.50

2. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй.

3. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

Завсрын аудитыг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрөөр тасалбар болгон 2025 оны 11 дүгээр сард гүйцэтгэж, аудитаар 174,904.4 мянган төгрөгийн 8 зөрчил илэрсэн. Тус зөрчлөөс жилийн эцсийн санхүүгийн тайланд 14,907.4 мянган төгрөгийн 2 алдааг залруулан бүртгэлд тусган, ОНХС-ийн шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 7,000.0 мянган төгрөгийн мэдээллийг нөхөн байршуулж, Удирдлагын мэдээллийн системд мэдээллийг бүрэн оруулж, 13,000.0 мянган төгрөгийн төсөл арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, актаар хүлээн авсан байна.

Завсрын аудитаар илэрсэн 140,000.0 мянган төгрөгийн худалдан авах ажиллагаанд өртэй аж ахуйн нэгж шалгаруулсан, хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний техникийн тодорхойлолтыг мэргэжлийн байгууллагаар хийлгэх, зураг төсөв магадлалаар баталгаажаагүй байхад сумын ИТХ-аар баталсан зөрчилд зөвлөмж өглөө.

4. Ерөнхий чиглэлийн судалгааны талаар

ҮАГ-аас нэгдсэн журмаар авч байгаа ерөнхий чиглэлийн 8 судалгаанаас хамааралтай дараах 1 судалгааг гаргаж ажлын баримтад хавсаргав.

- Мэдээллийн технологийн зардлын тухайд: Санхүүгийн нягтлан бодох бүртгэлийг "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн "ACOLOUS" программыг ашигладаг, тайлант жилийн хөгжүүлэлттэй холбоотой зардалд 238.0 мянган төгрөгийг төлжээ.

5. Аудитын илрүүлэлт

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 9,160.0 мянган төгрөгийн 1 алдааг санхүүгийн тайланд залруулсан. Үүнд:

1. Баянцагаан сумын төвөөс 60 км зайд ОНХС-ийн хөрөнгөөр Цагдуултайн тариалангийн талбайд усалгааны систем болон хөрсний чулуу түүх, арчлалт, тариалалт хийхээр "Жаргалант хун толгой" ХХК-тай 70,000.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж, үүнээс 10,000.0 мянган төгрөгөөр тэжээлийн ургамал тариалж, 30 га талбайгаас 458 боодол ногоон тэжээл авч, үүнээс 408 ширхэг ногоон тэжээлийг нэг бүрийг нь 20.0 мянган төгрөгөөр борлуулсан боловч тэжээлийн орлого, зарлагыг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байгаа нь Тохиолдсон байх, Иж бүрэн байх, Тасалбар болголт батламж мэдэгдлүүдийг хангаагүй тул санхүүгийн тайланд залруулсан.

Аудитаар "Сонголт дизайн" ХХК-тай холбоотой 219,625.0 мянган төгрөгийн 2 зөрчил илэрснээс 30,625.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн актыг тогтоож, 189,000.0 мянган төгрөгийн зөрчилд зөрчлийг арилгах хугацаатай албан шаардлага өглөө.

5.1. Төлбөрийн акт

Баянцагаан сумын Засаг дарга, "Сонголт дизайн" ХХК-ийн гүйцэтгэх захирал нарын хооронд 2025.05.15-ны өдөр байгуулсан ЗТ-01/25 тоот "Баянхонгор аймгийн Баянцагаан сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах" ажлын гэрээнд санхүүжилтийн 40 хувь буюу 81,000.0 мянган төгрөгийг баталгаажсан ажлын гүйцэтгэлийг үндэслэл болгож

1.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	175,681,827.50	175,681,827.50
D01	2025 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	175,681,827.50	175,681,827.50
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	175,681,827.50	175,681,827.50
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	75,975,087.00	75,975,087.00
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	251,656,914.50	251,656,914.50

1.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	828,703,400.00	654,105,399.00	174,598,001.00	78.93
2200	Дотоод эх үүсвэрээр	828,703,400.00	654,105,399.00	174,598,001.00	78.93
223001	Бусад хөрөнгө	828,703,400.00	654,105,399.00	174,598,001.00	78.93
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	828,703,400.00	773,190,904.00	55,512,496.00	93.30
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	647,802,100.00	637,753,900.00	10,048,200.00	98.45
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	647,802,100.00	637,753,900.00	10,048,200.00	98.45
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	734,304,000.00	720,873,986.00	13,430,014.00	98.17
132001	Орон нутгийн төсвөөс	86,501,900.00	83,120,086.00	3,381,814.00	96.09
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	94,399,400.00	52,316,918.00	42,082,482.00	55.42
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	45,281,900.00	52,316,918.00	-7,035,018.00	115.54
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	49,117,500.00	00.00	49,117,500.00	00.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	58,611,409.50		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	177,696,914.50		

олгоно гэж заасан байхад сумын ерөнхий төлөвлөгөөг хүлээн аваагүй байхад 2025.12.25-ны өдөр 30,625.0 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Баянцагаан сумын Засаг дарга, "Сонголт дизайн" ХХК-ийн гүйцэтгэх захирал нарын хооронд 2025.05.15-ны өдөр байгуулсан ЗТ-01/25 тоот "Баянхонгор аймгийн Баянцагаан сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах" ажлын гэрээний 3.2-(3)-т "Эцсийн тайлан буюу ерөнхий төлөвлөгөөний зургийг захиалагчтай зөвшилцсөний дараа төлөх дүн 40 хувь буюу 81,0 сая төгрөг, баталгаажсан ажлын гүйцэтгэлийг үндэслэл болгоно" гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Ажлыг бүрэн дуусгаагүй байхад гэрээний заалтыг зөрчин гүйцэтгэгчид олгосон 30,625.0 мянган төгрөгийг "Сонголт дизайн" ХХК-аар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

5.2. Албан шаардлага

Баянцагаан сумын Засаг дарга, "Сонголт дизайн" ХХК-ийн гүйцэтгэх захирал нар 2025.05.15-ны өдөр ЗТ-01/25 тоот "Баянхонгор аймгийн Баянцагаан сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах" ажлын гэрээг байгуулж, гэрээнд заасан ажлыг хэрэгжүүлээгүй тул 2025.10.01-ний өдөр ЗТ-01/25+1 тоот ажлын хугацааг сунгах гэрээг байгуулж, гэрээний хугацааг 2026.01.15-ны өдөр хүртэл сунгасан оловч ажлыг хүлээлгэж өгөөгүй байна.

Энэ нь Баянцагаан сумын Засаг дарга, "Сонголт дизайн" ХХК-ийн гүйцэтгэх захирал нарын хооронд 2026.01.15-ны өдөр байгуулсан ЗТ-01/25+1 тоот гэрээний 3-т заасан "Тус ажлыг гүйцэтгэхэд мэргэжлийн байгууллагууд болох аймгийн ГХБХБГ, Эрүүл мэндийн газар, Онцгой байдлын газар, Аймгийн ерөнхий архитектораас санал авч зөвшилцөх болон Барилгын хөгжлийн төвөөр "Магадлалын дүгнэлтийн нэгтгэл" гаргуулах зэрэг шалтгаанаар гэрээний хугацааг 2026.01.15-ны өдөр хүртэл сунгахыг хүлээн зөвшөөрөв" гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Мэргэжлийн байгууллагуудын дүгнэлтээр баталгаажсан Сумын ерөнхий төлөвлөгөөг актаар хүлээн авч, зөрчлийг арилган, шийдвэрийн хэрэгжилтийг санхүүгийн тайлангийн системд оруулах албан шаардлагыг хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Орон нутгийн хөгжлийн сангийн нягтлан бодогчид талархал илэрхийлье.

Тав. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл (мянган төгрөгөөр)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цагдуултайн тариалангийн талбайд тэжээлийн ургамал тариалж, 30 га талбайгаас 458 боодол ногоон тэжээл авч, үүнээс 408 ширхэг ногоон тэжээлийг нэг бүрийг нь 20.0 мянган төгрөгөөр борлуулсан боловч тэжээлийн орлого, зарлагыг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй.	1	9,160.0	1	9,160.0	0	0	1	9,160.0	0	0	0	0
ДҮН	1	9,160.0	1	9,160.0	0	0	1	9,160.0	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл (мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Баянцагаан сумын Засаг дарга, "Сонголт дизайн" ХХК-ийн гүйцэтгэх захирал нарын хооронд 2025.05.15-ны өдөр байгуулсан ЗТ-01/25 тоот "Баянхонгор аймгийн Баянцагаан сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах" ажлын гэрээнд санхүүжилтийн 40 хувь буюу 81,000.0 мянган төгрөгийг баталгаажсан ажлын гүйцэтгэлийг үндэслэл болгож олгоно гэж заасан байхад сумын ерөнхий төлөвлөгөөг хүлээн аваагүй байхад 2025.12.25-ны өдөр 30,625.0 мянган төгрөгийг олгосон байна	1	30,625.0	1	30,625.0	0	0	0	0
Баянцагаан сумын Засаг дарга, "Сонголт дизайн" ХХК-ийн гүйцэтгэх захирал нар 2025.05.15-ны өдөр ЗТ-01/25 тоот "Баянхонгор аймгийн Баянцагаан сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах" ажлын гэрээг байгуулж, гэрээнд заасан ажлыг хэрэгжүүлээгүй тул 2025.10.01-ний өдөр ЗТ-01/25+1 тоот ажлын хугацааг сунгах гэрээг байгуулж, гэрээний хугацааг 2026.01.15-ны өдөр хүртэл сунгасан оловч ажлыг хүлээлгэж өгөөгүй байна.	1	189,000.0	0	0	1	189,000.0	0	0
Дүн	2	219,625.0	1	30,625.0	1	189,000.0	0	0

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	Төсөл, хөтөлбөр	1		1					
	НИЙТ	1		1					

---oOo---



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 10 өдөр

Дугаар 4/АДСБ0238/БТНА-2026/020/НА-СТА-
ОУТС

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Баянцагаан сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Баянцагаан сумын Засаг дарга, "Сонголт дизайн" ХХК-ийн гүйцэтгэх захирал нарын хооронд 2025.05.15-ны өдөр байгуулсан ЗТ-01/25 тоот "Баянхонгор аймгийн Баянцагаан сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах" ажлын гэрээнд санхүүжилтийн 40 хувь буюу 81,000.0 мянган төгрөгийг баталгаажсан ажлын гүйцэтгэлийг үндэслэл болгож олгоно гэж заасан байхад сумын ерөнхий төлөвлөгөөг хүлээн аваагүй байхад 2025.12.25-ны өдөр 30,625.0 мянган төгрөгийг гүйцэтгэгчид олгосон байна.

Энэ нь Баянцагаан сумын Засаг дарга, "Сонголт дизайн" ХХК-ийн гүйцэтгэх захирал нарын хооронд 2025.05.15-ны өдөр байгуулсан ЗТ-01/25 тоот "Баянхонгор аймгийн Баянцагаан сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах" ажлын гэрээний 3.2-(3)-т "Эцсийн тайлан буюу ерөнхий төлөвлөгөөний зургийг захиалагчтай зөвшилцсөний дараа төлөх дүн 40 хувь буюу 81,0 сая төгрөг, баталгаажсан ажлын гүйцэтгэлийг үндэслэл болгоно", Баянцагаан сумын Засаг дарга, "Сонголт дизайн" ХХК-ийн гүйцэтгэх захирал нарын хооронд 2026.01.15-ны өдөр байгуулсан ЗТ-01/25+1 тоот гэрээний 3-т заасан "Тус ажлыг гүйцэтгэхэд мэргэжлийн байгууллагууд болох аймгийн ГХБХБГ, Эрүүл мэндийн газар, Онцгой байдлын газар, Аймгийн ерөнхий архитектораас санал авч зөвшилцөх болон Барилгын хөгжлийн төвөөр "Магадлалын дүгнэлтийн нэгтгэл" гаргуулах зэрэг шалтгаанаар гэрээний хугацааг 2026.01.15-ны өдөр хүртэл сунгахыг хүлээн зөвшөөрөв" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого

6426110012

бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь “Улсад болон байгууллагад хохирол учруулсан төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан” гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Ажлыг бүрэн дуусгаагүй байхад гэрээний заалтыг зөрчин гүйцэтгэгчид олгосон 30,625,000 (Гучин сая зургаан зуун хорин таван мянга) төгрөгийг "Сонголт дизайн" ХХК-аар төлүүлж, Баянцагаан сумын Орон нутгийн хөгжлийн сангийн Төрийн сан дахь 100031852400 тоот төгрөгийн дансанд төвлөрүүлэх.

2. Аудитаар тогтоосон төлбөрийн актыг бүрэн барагдуулж, нотлох баримтыг 2026 оны 02 дугаар сарын 13-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянцагаан сумын Засаг дарга Н.Гансүх, нягтлан бодогч Т.Одмаа нарт даалгав^{1,2}.

ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН³:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.МӨНХБАТ

АХЛАХ АУДИТОР



Б.ДОЛЖМАА

¹ Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана"

² Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

³ Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 12 өдөр

Дугаар 11/А-0580238/571А-2026/020/571А-Номгон
СА-ОНТС

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянцагаан сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Баянцагаан сумын Засаг дарга, "Сонголт дизайн" ХХК-ийн гүйцэтгэх захирал нар 2025.05.15-ны өдөр ЗТ-01/25 тоот "Баянхонгор аймгийн Баянцагаан сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах" ажлын гэрээг байгуулж, гэрээнд заасан ажлыг хэрэгжүүлээгүй тул 2025.10.01-ний өдөр ЗТ-01/25+1 тоот ажлын хугацааг сунгах гэрээг байгуулж, гэрээний хугацааг 2026.01.15-ны өдөр хүртэл сунгасан оловч ажлыг хүлээлгэж өгөөгүй байна.

Энэ нь Баянцагаан сумын Засаг дарга, "Сонголт дизайн" ХХК-ийн гүйцэтгэх захирал нарын хооронд 2026.01.15-ны өдөр байгуулсан ЗТ-01/25+1 тоот гэрээний 3-т заасан "Тус ажлыг гүйцэтгэхэд мэргэжлийн байгууллагууд болох аймгийн ГХБХБГ, Эрүүл мэндийн газар, Онцгой байдлын газар, Аймгийн ерөнхий архитектораас санал авч зөвшилцөх болон Барилгын хөгжлийн төвөөр "Магадлалын дүгнэлтийн нэгтгэл" гаргуулах зэрэг шалтгаанаар гэрээний хугацааг 2026.01.15-ны өдөр хүртэл сунгахыг хүлээн зөвшөөрөв" гэсэн заалт болон УСНББОУС 29 Санхүүгийн хэрэглүүр: хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт, НББОУС 39 Санхүүгийн хэрэглүүр: хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.4 голч, бодитой байх, санхүүгийн тайланд багтсан мэдээлэл ямар нэгэн нөлөөнд автаагүй байх" гэснийг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх "хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан

6426030032

/documents/2026 он/1. бичиг
хэрэг/тоот/4. албан шаардлага 2026.docx

гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Мэргэжлийн байгууллагуудын дүгнэлтээр баталгаажсан Сумын ерөнхий төлөвлөгөөг актаар хүлээн авч, зөрчлийг арилган, шийдвэрийн хэрэгжилтийг санхүүгийн тайлангийн системд оруулж, нотлох баримтыг 2026 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх

2. Цаашид орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл, арга хэмжээний гэрээнд хууль, тогтоомжид нийцүүлэн гэрээний заалтыг тодорхой тусгах, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд мэргэжлийн байгууллагын хяналтыг тухай бүрд хийж, ажлыг гэрээнд заасан хугацаанд нь чанартай гүйцэтгүүлж ажиллахыг Баянцагаан сумын Засаг дарга Н.Гансүх, нягтлан бодогч Т.Одмаа нарт даалгав^{1,2}.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: **Б.МӨНХБАТ**

АХЛАХ АУДИТОР

Б.ДОЛЖМАА



¹ Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

² Монгол улсын ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

³ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно